Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/51 дүгээр тушаалаар нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтэст Зөрчлийн хэрэг бүртгэх тасаг, А/123 дугаар тушаалаар нэгжийн саналыг үндэслэн Заамар сумын сум дундын цагдаагийн хэлтэст Эрүүгийн цагдаагийн хэсэг, А/293 дугаар тушаалаар цагдаагийн газрын нэршлийг тус тус өөрчилсөн байна.

Тайлант хугацаанд 718 гэмт хэрэг бүртгэгдэж 151 хэргээр буюу 26,6 хувиар гэмт хэргийн илрүүлэлт сайжирсан. Хэрэг бүртгэлтийн 631 хэрэг бүртгэгдсэний 399 хэргийг илрүүлж, илрүүлэлт 63,2 хувьтай, өмнөх онтой харьцуулахад илрүүлэлт 3 хувиар өссөн байна.

Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад 7,094.0 сая төгрөгийн хохирол учирч үүнээс 3,987.0 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, хохирол нөхөн төлүүлэлт 56.2 хувьтай байна.

Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор ЦЕГ болон цагдаагийн газраас “Сар шинэ-2022”, “Илрүүлэлт-Оргодол-2022” “Оргодол”, “Алдуул мал”, “Эрэн сурвалжлалт-2022”, “Шийдвэрлэлт”, “Мал мах-2022” зэрэг нийт 10 нэгдсэн арга хэмжээ болон 21 хэсэгчилсэн арга хэмжээ, бусад ажиллагааны хүрээнд ASAP санд тайлант онд 669 эрэн сурвалжлалт зарлаж, 612 мэдээллийн эрэн сурвалжлалтыг зогсоож эрэн сурвалжлах ажлын гүйцэтгэл 91.4 хувьтай ажилласан байна.

Цагдаагийн газрын шинээр баригдах конторын барилгын зураг, төсвийн ажлыг “Амайзэ” ХХК-аар гүйцэтгүүлэн 44.5 сая төгрөгийг Төв аймгийн Засаг даргын Тамгын газраар, Баян, Баянчандмань, Батсүмбэр, Бүрэн, Эрдэнэсант сумдад баригдах цагдаагийн хэсгийн төлөөлөгчийн байр /кобан/-ны зураг төсвийн ажлыг 179.6 сая төгрөгөөр Алтан хөхийн очир ХХК-иар гүйцэтгүүлж, Барилга хот байгуулалтын ямаар хөрөнгийг шийдвэрлүүлсэн байна.

Төв аймгийн Цагдаагийн газар нь аймгийн засаг даргатай 2022 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 29 хэрэгжүүлэх арга хэмжээтэй баталснаас хэрэгжилт 87.5%-тай “В” үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Төв аймгийн Цагдаагийн газар нь нэгдмэл төвлөрсөн удирдлагатай ба Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/135, 2018 оны А/58, А/212, 2019 оны А/137 2020 оны А/17, А/214, А/268, А/316, 2021 оны А/30, 2022 оны А/51 дүгээр тушаалаар офицер 129, ахлагч 90, энгийн 3, бүгд 222 орон тоотой батлагдсан. Одоогийн байдлаар офицер 111, ахлагч 84, энгийн 3, бүгд 198 орон тоотойгоор /офицер 18, ахлагч 6 орон тоо дутуу, нөхөн хангалт 89.1 хувьтай /үйл ажиллагаагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Цагдаагийн газар нь цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2022 онд дэвшүүлсэн зорилт, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 дүгээр албан даалгавар, Засгийн газрын 2018 оны “Төрийн алба хаагчийн сахилга хариуцлагыг сайжруулах тухай” 258 дугаар тогтоол, Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын

цэргийн командлагч, дэд даргаас ирүүлсэн үүрэг, ажлын чиглэлийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт, гадаад, дотоод орчны хурдацтай өөрчлөлт нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг шинэ түвшинд гаргах хэрэгцээг бий болгож байна. Мөн гадаад, дотоод болон олон улсын байгууллагатай харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааг сайжруулахаар ажиллаж байна.

Төв аймгийн Цагдаагийн газар нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Цагдаагийн албаны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд буюу хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн өөрчлөлттэй холбоотойгоор Цагдаагийн ерөнхий газар нь хөдөлмөрийн дотоод журам болон холбогдох баримт бичигт орсон өөрчлөлтийг нэгжүүдэд ирүүлэн мөрдөж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, шаардлагатай гэж үзсэн.

Цагдаагийн ерөнхий газрын Дотоод аюулгүй байдал хяналт шалгалтын хэлтсээс дотоод аудитын үйл ажиллагааг удирдан явуулдаг, дотоод аудитор 2 орон тоотой ажилладаг ба батлагдсан төлөвлөгөө, хуваарийн дагуу салбар нэгжид хяналт шалгалтыг явуулж үр дүнг бүх нэгжүүдэд мэдээлэн цахимаар ярилцлага хийж удирдлага зохион байгуулалтаар ханган ажилладаг байна.

ЦЕГ-ын Дотоод хяналт аюулгүй байдлын газраас 2022 онд дотоод аудитын шалгалтыг хийж 2021 оны дотоод аудитын шалгалтын биелэлт, 2022 оны 11 дүгээр сар хүртэлх санхүүгийн баримтыг хамруулан шалгасан ба алдаа зөрчил илрээгүй байна.

Цагдаагийн Ерөнхий газрын Дотоод хяналт аюулгүй байдлын газрын дарга 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдөр тус цагдаагийн газарт ажиллаж, алба хаагчидтай уулзалт хийж, "Байгууллага, алба хаагчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр анхаарах асуудал" сэдвээр сургалт зохион байгуулж, сургалтад төвийн бүрэлдэхүүн танхимаар, Заамар сум дахь сум дундын цагдаагийн хэлтэс, Эрдэнэ сум дахь цагдаагийн тасаг, Баян, Баянчандмань сумын цагдаагийн хэсэг, хэсгийн төлөөлөгч, цагдаа, зохицуулагч нар цахимаар хамрагдсан байна.

Цагдаагийн газар нь Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн "Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2022 онд хэрэгжилтийг хангах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, биелэлт, үр дүнг тооцох баримт бичгийн жагсаалт батлах тухай" 2022 оны А/38, тушаалын хавсралтад өөрчлөлт оруулах тухай А/197 тоот тушаалыг хэрэгжүүлэх салбар

төлөвлөгөөг гарган биелэлт, үр дүнг тооцон хяналт шинжилгээ үнэлгээ хийж тогтоосон хугацаанд холбогдох албадад тайлагнах талаар хэлтэс, тасгийн дарга нарт мэдэгдэж танилцуулсан талаар тэмдэглэл хөтлөн биелэлтийг тооцож ажилласан байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Цагдаагийн газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Цагдаагийн ерөнхий газрын 2013 оны 12 дугаар сарын 10-ны А/188 дугаар тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа ба тус бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Цагдаагийн газар нь 2022 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 50,831.8 мянган төгрөгөөр буюу 3.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	15,113.4	15,113.4
Урьдчилгаа	0	0	
Авлага	0	0	
Бараа материал	257,531.4	281,697.8	24,166.4
Үндсэн хөрөнгө	1,186,439.7	1,096,327.1	-90,112.6
Нийт хөрөнгө	1,443,971.1	1,393,138.3	-50,832.8
Өр төлбөр		0	
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,443,971.1	1,393,138.3	-50,832.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,443,971.1	1,393,138.3	-50,832.8

Дээрх хүснэгтээс харахад, Төрийн сан дахь Ахмадын сангийн 100140012505 тоот дансанд 15,113.4 мянган төгрөгийн үлдэгдлийг мөнгөн хөрөнгийн дансанд тайлагнасан нь өмнөх оны үзүүлэлтээс өссөн өөрчлөлт гарсан байна.

Бараа материалын дансанд орлого зарлагын хөдөлгөөн хийгдэж, Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон ЦЕГ-аас 17,069.2 мянган төгрөгийн цахилгаан бороохой, сум, энгэрийн камер, гав зэрэг тусгай зориулалтын хэрэгсэл, 5,476.8 мянган төгрөгийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын эмхэтгэл ном, хар тамхи илрүүлэгч тест, замын хаалт, нөмрөг, саатуулах байрны багаж хэрэгсэл зэрэг бусад хангамжийн материал, шатахууны талоны урамшуулалд 2,129.0 мянган төгрөгийн шатахуун, малын нас дэвшилт,

төлийн орлогоор 14,398.6 мянган төгрөгийн бараа материалыг тус тус үнэ төлбөргүй шилжүүлэн авсан нь дансны үлдэгдлийг 24,166.4 мянган төгрөгөөр өсөхөд нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансанд төсвийн хөрөнгөөр 26,725.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 15,124.3 мянган төгрөгийн, ЦЕГ-с 47,953.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авч, 217,925.6 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж нийт 307,729.8 мянган төгрөгийн хөрөнгө орлого авч, 92,194.2 мянган төгрөгийн 11 тээврийн хэрэгслийг сумдын ЗДТГ-т балансаас баланст шилжүүлж, 240,043.3 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгахаар данснаас хасалт хийж, 93,615.2 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хасаж, нийт 425,852.7 мянган төгрөгийн зарлагын хөдөлгөөн хийгдсэн болон хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалан өмнөх оны үзүүлэлтээс 90,112.6 мянган төгрөгөөр үлдэгдэл буурч нөлөөлсөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,393,138.3 мянган төгрөг болж 50,832.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Цагдаагийн газрын 2008 онд дахин үнэлгээ хийгдсэн нэг барилга байгууламжийг аймгийн ИТХ-ын 2022 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн 14 дүгээр тогтоолоор акталж, устгасантай холбоотойгоор хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл үзүүлэлт 2,628.4 мянган төгрөгөөр буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 4,957,848.3 мянган төгрөг, үйл ажиллагааны орлого 5,100.0 мянган төгрөг, нийт зарлагыг 4,962,948.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Цагдаагийн газраас дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 95,466.5 мянган төгрөгөөр бууруулан ЦЕГ-ын Санхүү, аж ахуйн албаны 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 6/1912 тоот албан бичгээр 2022 оны урсгал зардлын төсвийг 4,017,481.8 мянган төгрөгөөр баталж, ирүүлсэн байна.

Тайлант хугацаанд 2022 оны 11 дүгээр сард 4,049,978.9 мянган төгрөгөөр тодотгон 1 удаа өөрчлөлт хийгдсэн байна.

Энэ нь 2022 оны төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй эсвэл тухайн байгууллагын төсвийн төсөлд хүргүүлсэн саналд үндэслэдэггүй баталдгаас шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөв 4,017,481.8 мянган төгрөгийг 32,497.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1 удаа тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх Гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэх 3,963,219.3 мянган төгрөг, Гэрч хохирогчийг хамгаалах хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэх 86,759.6 мянган төгрөг, нийт 4,049,978.9 мянган төгрөгийг зардлыг, улсын төсвөөс 4,031,978.9 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 18,000.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр батлагдсаны дагуу гүйцэтгэлээр зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 100 хувь олгож, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 5,489.8 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,049,950.6 мянган төгрөг буюу 99,9 хувьтай байгаа нь улсын төсвийн санхүүжилтээс 28.4 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогыг давуулан биелүүлсний 5,461.4 мянган төгрөг, нийт 5,489.8 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70704 –Цагдаа гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	3,929,604.4	3,933,095.7	-3,491.3	100%
2	70704 –Цагдаа гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах 80802 –Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	23,614.9	22,684.9	930.0	96%
3	70704 –Цагдаа гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах 82315- Байцаан шийтгэх ажиллагаа	10,000.0	6,485.4	3,514.6	65%
4	70711-Шүүгч болон гэрч хохирогчийг хамгаалах 80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	86,759.6	87,684.6	-925.0	101%
	Дүн	4,049,978.9	4,049,950.6	28.4	99.9%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Цагдаагийн газар нь 2022 онд нэмэлт санхүүжилтийн дансанд ЦЕГ-с 1,688.5 мянган төгрөг, аймгийн Засаг даргын нөөц сангаас 2,000.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөнөөс давсан 10,833.1 мянган төгрөг, аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 11,213.0 мянган төгрөг, тендерийн материалын 105.0 мянган төгрөг, галт зэвсгийн сургалтын 19,180.0 мянган төгрөг, нийт 45,019.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг 16,200.0 мянган төгрөгөөр илүү төвлөрүүлж, давсан орлогыг Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 74 дүгээр тушаалд заасан зардалд зарцуулахаар хамт олны хурлаар хэлэлцүүлэн нэн шаардлагатай техник хэрэгслийг бэлтгэх, өр, авлагыг барагдуулахад зарцуулсан.

Нэмэлт санхүүжилтийн данснаас байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын өр төлбөрт 4,775.4 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 5,999.6 мянган төгрөг, нормативд зардалд 2,784.0 мянган төгрөг, эд хогшил худалдан авах зардалд 13,162.6 мянган төгрөг, дотоод албан томилолтын зардалд 900.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 235.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 17,163.0 мянган төгрөгийг тус тус зарцуулж тайлагнасан байна.

Нэмэлт санхүүжилтийн орлого, зардлыг зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Ахмадын сан

Цагдаагийн газар нь ахмадын сангийн 100140012505 тоот дансыг нээлгэж, ЦЕГ-аас 1 дүгээр сард 11,936.8 мянган төгрөгийн санхүүжилт, 12 дугаар сард ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшууллын зардалд 13,416.0 мянган төгрөгийг санхүүжилт олгосныг ахмадын санд шилжүүлэн, нийт 25,352.8 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

Тус байгууллага 96 ахмад настантай бөгөөд 10,995.2 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж, Цагдаагийн газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 103 тоот тушаалаар ахмадын зөвлөл байгуулагдсан байна.

ЦЕГ-ын Санхүү, аж ахуйн албанаас 2022 оны 12 дугаар сарын 09-ны өдөр ирүүлсэн 14/1772 тоот үүрэг ажлын чиглэл, Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6 дахь заалт, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор батлагдсан” Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын дагуу цалингийн сангийн хэмнэсэн үлдэгдлээс 755.8 мянган төгрөгийг өөрийн байгууллагын Ахмадын сангийн дансанд шилжүүлэн, мөнгөн хөрөнгийн үлдэгдлээр 15,113.4 мянган төгрөгийг тайлагнасан байна.

Ахмадын сангийн орлого, зардлыг зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.7-д харуулав.

3.5.5 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт хоёр хөтөлбөрийн дөрвөн арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70704 –Цагдаа гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах	2022.01.01-2022.12.31	Гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах	Бүрэн хэрэгжсэн, биелэлт 100%	3,963,219,3	3,962,266,0
2	70711-Шүүгч болон гэрч хохирогчийг хамгаалах	2022.01.01-2022.12.31	Шүүгч болон гэрч хохирогчийг хамгаалах	Бүрэн хэрэгжсэн, биелэлт 100%	86,759,6	87,684,6

Төв аймгийн Цагдаагийн газар нь төсвийн хэмнэлтийн горимд шилжин ажилласнаар Гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах хөтөлбөрөөс 953.3 мянган төгрөгийн зардлыг хэмнэж, Гэрч хохирогчийг хамгаалах хөтөлбөрт зайлшгүй хэрэгцээ шаардлагатай 925.0 мянган төгрөгийн зардлыг шилжүүлэн зарцуулж тайлагнасан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Цагдаагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баянжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Цагдаагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 45/01-286 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Цагдаагийн газрын 2022 оны баталсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Цагдаагийн газрын 2022 оны батлагдсан төсвийн нийт зарлага 4,049,950.6 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 60,262.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 45,196.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага авч хэрэгжүүлсэн ажлын тайланг 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай хамт хавсаргаж, ирүүлсэн. Үүнд: Тус байгууллагын 2022 оны шаардлагатай гэж төсөвлөсөн төсвөөс 18 хувиар бууруулан баталсан ба төсвийн хэмнэлтийн горимд шилжин ажилласнаар нийт 5,489.8 мянган төгрөгийн зардлыг хэмнэж, зарцуулаагүй үлдэгдлийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсөв бууруулснаас шалтгаалан түлш халаалт, гэрэл цахилгааны зардалд өр үүссэн байсан тул цагдаагийн газрын давсан орлогын 10,833.1 мянган төгрөгөөс түлш халаалтын зардалд 2,726.7 мянган төгрөг, гэрэл цахилгааны зардалд 2,048.8 мянган төгрөгийг шилжүүлж, өр төлбөрийг барагдуулсан байна.

Цагдаагийн газрын алба хаагчдад сар бүр олгодог байсан 5.0 мянган төгрөгийн нэгж олголтыг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтыг хэрэгжүүлэн 2022 оны 5 дугаар сараас эхлэн олгоогүй байна.

“Ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувиллын газарт, эсхүл өөрийн болон эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутагт амрах тохиолдолд түүний очих, ирэх замын зардлыг олгохгүй” байх

заалтын дагуу цагдаагийн газрын алба хаагчдад 2022 онд замын зардал олгоогүй, хууль тогтоомжид зааснаас бусад хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгоогүй байна.

Албан томилолт, хичээл сургалтын зардлыг хэмнэн, сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын нэгдсэн сургалтыг улирал бүр хийдэг байсныг цахим хэлбэрт шилжүүлж, хөдөө орон нутагт томилолтоор ажиллаж байгаа алба хаагчдын байрны зардлыг олгохгүй сумдын хэсгийн төлөөлөгч нарын байр/ кобан/-д байрлуулж бодит хэмнэлтийг бий болгожээ.

Тус цагдаагийн газарт чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоосон тохиолдол гараагүй Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаж, үндсэн үйл ажиллагааны давсан орлогын 5,489.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж ажилласан.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Цагдаагийн газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад Тендер шалгаруулсан худалдан авах ажиллагааны 1 мэдээлэл, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 16 орлогын, 47 зарлагын мөнгөн гүйлгээг болон өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 239 шийдвэрийг хугацаандаа байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Цагдаагийн газрын эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад асуудлын бүртгэлээр 2 зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг тайлбарын хамт Цагдаагийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 45/01-280 дугаар албан бичгээр ирүүлсэн. Биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад үр дүнтэй хэрэгжсэн тул аудитын тайланд тусгаагүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангийн 1 зөвлөмж өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2022 оны 6 дугаар сарын 20-ны өдөр ирүүлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	1	0.00	1	0.00	100
Нийт дүн	1	0.00	1	0.00	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Цагдаагийн газрын дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар цалин, шимтгэлийг мөнгөн гүйлгээний тайлан, үр дүнгийн тайланд 461.3 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан алдаа илэрсэн байсныг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу аудитын явцад залруулсан.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА,ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

мянган төгрөгөөр

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуул- сан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
							залруулсан		залруулаагүй			
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
Санхүүгийн тайлангийн уялдааг нягтлахад, тайланг иж бүрэн тайлагнаж, тодруулга тайлбарыг үнэн зөв бэлтгэсэн байна. Цалин, шимтгэлийг мөнгөн гүйлгээний тайлан, үр дүнгийн тайланд 461.3 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.	1	461.3			1	461.3	1	461.3				
Дүн	1	461.3	0	0.0	1	461.3	1	461.3	0	0.0	0	0.0

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

мянган төгрөгөөр

Алдааны товч утга	Нийт зөрчил		Үүнээс:									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
	0	0.0										
Дүн	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

мянган төгрөгөөр

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Дүн	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0	0.0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Дүн	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0	0.0
Нийт дүн	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0	0.0